



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 6/03

Чойр хот

Б.Батчимэгийг Газрын даамлаар
томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.6 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 253 дугаар тогтоол, 2014 оны 332 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Баянтал сумын ЗДТГ-ын 2018 оны 04 тоотыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор сумын Засаг даргын Тамгын газрын бүтцэд ажиллаж байгаа Газрын даамлыг аймгийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад шилжүүлэхтэй Баянтал сумын Газрын даамлаар Бат-Очирын Батчимэгийг 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Ажлын байрны тодорхойлогод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх, үр дүнгийн гэрээг жил бүр байгуулан хагас, бүтэн жилээр дүгнүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахин ажиллахыг Баянтал сумын Газрын даамал Б.Батчимэгт үүрэг болгосугай.

3. Баянтал сумын Газрын даамал Б.Батчимэгийн албан тушаалын үндсэн цалинг ТЗ-3-1 дэх шатлалаар буюу 464783 /дөрвөн зуун жаран дөрвөн мянга долоон зуун наян гурван/ төгрөгөөр цалинжуулахыг Ахлах нягтлан бодогч /Л.Туяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Д.ТАМИР

0800168